

**Холбооны үйл ажиллагааны үндсэн чиглэл:** Шүүгч гишүүдийнхээ хууль ёсны эрх ашгийг хамгаалах, тэдний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Тус холбооны эрх барих дээд байгууллага нь Нийт гишүүдийн хуралдаан буюу **“Холбооны Их хурал”** бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Холбооны дүрэм, үйл ажиллагааны үндсэн чиглэл, төлөвлөгөө батлах, нэмэлт өөрчлөлт оруулах;
- Холбооны удирдах зөвлөлийн ажлын тайланг хэлэлцэх, мэдээлэл сонсох;
- Холбооны хяналтын зөвлөлийн тайланг хэлэлцэх, мэдээлэл сонсох;
- Холбооны удирдах болон хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгох;
- Шүүгчдийн холбооны тэргүүнийг сонгох
- Холбоог өөрчлөн байгуулах, бүтэц зохион байгуулалтыг тогтоох, татан буулгах;
- Холбооны гишүүдийн татварын хэмжээг тогтоох;
- Дүрэмд заасан бусад бүрэн эрх зэрэг болно.

Шүүгчдийн холбоо нь: “Тэргүүн”-тэй байх ба **холбооны тэргүүн нь** дараах бүрэн эрхийн хүрээнд:

- Шүүгчдийн холбоог дотоод, гадаадад төлөөлөх
- Удирдах зөвлөлийн хуралдааныг зарлах хуралдуулах
- Холбооны ажлын төлөвлөгөөг батлах, биелэлтэнд нь хяналт тавих
- Холбооны мөнгө, хөрөнгө /гишүүдийн татвар, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллагын хандив тусламж/-ийг хуримтлуулах, аривжуулахтай холбогдсон ажил зохион байгуулах;
- Холбооны мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах;
- Бүрэн эрхийнхээ хүрээнд захирамж гаргах;
- Дүрэмд заасан бусад эрхийг хэрэгжүүлдэг.

Шүүгчдийн холбооны **“Гүйцэтгэх захирал”** нь холбооны өдөр тутмын үйл ажиллагааг

удирдан зохион байгуулж, дараах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Холбооны ажлын төлөвлөгөөг боловсруулах, биелэлтийг зохион байгуулах, хангах;
- Удирдах зөвлөлийн хуралдааны бэлтгэл ажлыг зохион байгуулах;
- Удирдах зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлэх;
- Гишүүний татвар, иргэд аж ахуйн нэгжийн болон олон улсын байгууллагын хандив тусламжийг бүрдүүлэх, захиран зарцуулах санал

боловсруулах;

- Холбооны гишүүдийн анкет, холбогдох бусад баримт материалыг бүрдүүлэх, хадгалах, хөдөлгөөн хийх;
- Холбооны албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтийг хариуцаж хадгалах;
- Холбооны дүрэмд заасан бусад бүрэн эрх.

Монголын Шүүгчдийн холбоо 2013 оны 5 дугаар сарын 02-ны өдөр анхны нийт гишүүдийн Их хурлаа хийж **“Монголын Шүүгчдийн Холбооны дүрэм”**-г баталсан ба уг дүрмээр Шүүгчдийн холбооны гишүүний татварын хэмжээг 6.000 төгрөг байх, үүнээс 1.000 төгрөгийг тухайн салбар хорооны үйл ажиллагаанд зарцуулах, 5.000 төгрөгийг Шүүгчдийн холбоонд төвлөрүүлэхээр тогтоосон байна.

Монголын Шүүгчдийн холбоо нь 2012 онд Олон Улсын Шүүгчдийн холбооны гишүүнээр элсэн орж, Монгол Улсын нийт 117 шүүхийн 527 шүүгчдийг эгнээндээ нэгтгэн *“Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, бэхжүүлэхэд тус дөхөм үзүүлэх, шүүгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, мэдлэг чадварыг дээшлүүлэх, Олон Улсын Шүүгчдийн холбооны болон гадаад орны шүүх, хуулийн байгууллагуудтай хамтран ажиллах үндсэн зорилго”*-ыг биелүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилладаг бөгөөд өнөөдрийн байдлаар 117 шүүхийн нийт 47 салбар хороог хамран үйл ажиллагаа явуулж байна.

2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр тус холбооны “Тэргүүн”-ээр Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч Ж.Оюунтунгалаг холбооны нийт гишүүдийн 86.2 хувийн саналаар сонгогдож, холбооны Гүйцэтгэх захирлаар олон жил шүүгчээр ажиллаж байсан Т.Туяа томилогдон ажиллаж байна.

Тус холбооноос шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүх эрх мэдлийн тогтолцоог боловсронгуй болгох, шүүгч, шүүхийн байгууллагын эрх зүйн байдал, үйл ажиллагааг тогтоосон хуулиудад заасан шүүгчийн эрх мэдлийг хэрэгжүүлэх баталгааг хангуулахад шаардлагатай асуудлаар гишүүдийнхээ дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, саналыг нэгтгэн хууль санаачлагч болон хууль тогтоох байгууллагад хүргүүлэх, мөн холбооны үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр таниулах, энэ чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцаа тогтоох, хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Та бүхэндээ ажлын амжилт хүсье.